



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Уланбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreatrural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2021.10.04 № 87.

Г Асуулга тавих тухай

Намрын сүүл сар гарч, цаг агаарын байдал сэргүүч, Улаанбаатар хотын гэр хорооллын айл өрхүүд галлагаагүйгээр шөнийг давах боломжгүй өдрүүд эхлээд байна.

Улаанбаатар хотын утааг бууруулах төсөл, хөтөлбөрүүдийн үр дүнд бий болж, үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байсан, сайжруулсан шахмал түлшний хэрэгцээг хангах боломжтой хувийн хэвшлийн олон аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг 2018 онд зогсоож, улмаар төрийн өмчит хуулийн этгээд байгуулан сайжруулсан шахмал түлш үйлдвэрлэж эхэлсэн. Түүнчлэн Засгийн газрын 2018 оны 62 дугаар тогтоолоор иргэдийг түүхий нүүрс, бусад шатах материал түлэхийг хориглож, төр иргэдийг түлшээр хангах, дулаан өвөлжих үүргийг дангаараа хүлээсэн.

Шенэдээ хасах хэмтэй болж хүйтрэн, Коронавируст халдварт /Ковид-19/-ын дэгдэлтэй эрчимжиж, олон иргэд амь нас, эрүүл мэндээрээ хохирч байгаа өндөр эрсдэлтэй энэ уед сайжруулсан шахмал түлшний хомсдол үүсээд байгаа нь иргэдийн эрүүл мэнд, амь насанд аюул учруулах нөхцөл байдлыг улам даамжруулах эрсдэлтэй байна.

Энэ бүх хариуцлагыг „Тавантолгой түлш“ ХХК, түүний хувьцаа эзэмшигч Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, улмаар Таны тэргүүлсэн Засгийн газар хүлээх учиртай.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 39 дүгээр зүйлийн 39.1.1-т тус тус заасныг үндэслэн Монгол Улсын Ерөнхий сайд Танд дараах асуултыг тавьж байна. Үүнд:

1. Сайжруулсан шахмал түлшний хомсдол үүсээд байгаа өнөөгийн бодит шалтгаан, нөхцөлийн талаар;

2. Иргэд амь нас, эрүүл мэндээрээ хохирох энэхүү нөхцөл байдалд хүргэсэн албан тушаалтнуудад хэрхэн хариуцлага хүлээлгэх гэж байгаа талаар;


3. Өвөлжилтийн бэлтгэл ажил, сайжруулсан шахмал түлшний хангамжийг хэвийн болгох талаар Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар зэрэг болно.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3-д заасан хугацаанд ирүүлж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулна уу.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Г.ДОРЖХАНД



2021000197